Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТЭС
АЯЛЛЫН БҮТГЭЭГДЭХҮҮНИЙ ХӨГЖҮҮЛЭЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
БАТДЭЛГЭРИЙН ЭНХЦЭЦЭГ
2024ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1: Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго 1: Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн байна. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4** | | | | | | | |
| **Зорилго Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4.1** | | | | | | | |
| 1. | Дэд арга хэмжээ- 1.1: "Бүргэдийн баяр 2024" арга хэмжээ зохион байгуулна. | Арга хэмжээ, оролцогч, үзэгчдийн тоо | 1 арга хэмжээ 11,000 хүн | 1 арга хэмжээ 16,000 | Нийслэлийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/180 дугаар захирамж, тус газрын даргын А/05 тоот тушаалаар "Бүргэдийн баяр 2024" арга хэмжээ зохион байгуулах 2024 оны 03 дугаар сарын 09,10-ны өдрүүдэд 11:00-18:00 цагийн хооронд зохион байгуулсан. Уг арга хэмжээг Баян-Өлгийн аймгийн Соёл урлагийн газар, "Монголын Бүргэдчид" холбоо ТББ, "Чингис хааны хүрээ" аялал жуулчлалын цогцолбортой хамтран Хан-Уул дүүргийн 08 дугаар хороо, Богдхан уулын Жаргалантын аманд байрлах "Чингис хааны хүрээ" аялал жуулчлалын цогцолбор газарт зохион байгуулсан. Арга хэмжээний үед 20,000 гаруй гадаад дотоодын жуулчид ирж сонирхсоноос бүргэд, шонхортой зураг авахуулах үйлчилгээг 4500 хүн, тэмээ унах, морь унах, нум сум харвах үйлчилгээг 2900 хүн, үндэсний хэв шинж бүхий бүтээгдэхүүн худалдаагаар /каз, монгол дээл, цүнх, малгай, бэлэг дурсгал, сувинер, | 2024.03.05 2024.03.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | саван/ 3764 гаруй хүн үйлчлүүлсэн байна. Эдийн засгийн үр өгөөжийг тооцож үзвэл Нийслэлийн төсвөөс 20,050,000 төгрөг зарцуулж, дэмжигч байгууллага Байгаль орчин, Аялал жуулчлалын яамнаас 10,000,000 төгрөгийг зарцуулж, 60 аж ахуй бизнес эрхлэгчид оролцож, наадмыг зохион байгуулснаар хотын эдийн засагт болон бизнес эрхлэгчдэд 424,803,600 төгрөгийн шууд бус орлогыг нийслэлийн төсөвт оруулжээ. | | |
| 2. | Арга хэмжээ- 1.2: "Тэнгэр" бөөгийн олон улсын фестиваль зохион байгуулна. | Арга хэмжээ, оролцогч, үзэгчдийн тоо | 1 арга хэмжээ 5,000 хүн | 1 арга хэмжээ 8,000 хүн | Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/526 дугаар захирамжаар "Монгол уламжлалт ёс заншлын салшгүй чухал соёлын өв болох зан заншлыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж, нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор "Тэнгэр" олон улсын фестивалийг "Хүй долоо худагт" 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрөөс 26-ны өдөр "Тэнгэр тайлал" ТББ- тай хамтран 2 дахь жилдээ зохион байгуулсан.<br>Уг арга хэмжээнд 30 улсын 750 гаруй бөө мэргэлчид Улаанбаатар хотноо хуран цугларсан бөгөөд гадаад 29 улсын 250 гаруй бөө, Монголын 19 бөөгийн холбооны 500 гаруй бөө оролцсон. 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдөр олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Чингис хааны музейн хурлын танхимд зохион явуулсан. Эрдэм шинжилгээний хурлаар бөөгийн үүсэл хөгжил, бөө тэнгэр шүтлэгийн хүн төрөлхтөнд үзүүлэх ач холбогдол, бөө өөрийн нутаг орон, байгалийнхаа төлөө хийх зан үйл болон Дэлхийн цэнгэг усны талаар хэлэлцэж, эрдэмтэн судлаачид өөрсдийн хийсэн судалгааны ажлаа танилцуулсан. Эрдэм шинжилгээний хуралд 26 гадаад бөө, 19 монгол бөө илтгэлээ тавьж, хэлэлцүүлэг өрнүүлж, 200 гаруй хүн оролцсон.<br>2024 оны 05 дугаар сарын 25, 26-ны өдрүүдэд Хүй долоо худагт дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулагдсан. Үүнд Нарны тахилга, Туг, сүлд залах ёслол, Бөөгийн парад, Урлагийн тоглолт, Бөө нар үзүүлбэр, Хайрхан буюу Лусын тахилга, Галын тахилга | 2024.05.24<br>2024.05.26 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | их гал болон 12 жилийн тахилга, 7 өвгөн одны тахилга, Дэлхийн амар амгалангийн төлөөх зан үйл, Урианхай сурын харваа, Хүчит 64 бөхийн барилдаан, Хурдан морины уралдаан (соёолон нас), Шагайн харваа (өсвөрийн насны тамирчид), Олон улсын бөө нарын их галын тахилга зэрэг арга хэмжээнүүдийн хуваарийг дагуу зохион явуулсан. Дээрх арга хэмжээг үзэж сонирхохоор аяллын байгууллагаар дамжин ирсэн 100 гаруй жуулчид, хувиараа аялж буй 400 гаруй жуулчин, 10,000 гаруй дотоодын иргэд үзэж сонирхсон байна. Арга хэмжээний үеэр талбайд 52 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, 20 хоол үйлдвэрлэлийн газрууд гарч гадаад дотоодын үйлчилгээ үзүүлэн ажилласан. Зах зээлд 1,5 тэрбум төгрөг оруулсан байна. | | |
| 3. | Арга хэмжээ-1.3:"Даншиг наадам-Хүрээ цам" шашин, соёлын наадам зохион байгуулна. | Арга хэмжээ, оролцогч, үзэгчдийн тоо | 1 арга хэмжээ хүн | 1 арга хэмжээ хүн | "Даншиг наадам-Хүрээ цам" 2024 шашин, соёлын наадам зохион байгуулах ажлын хэсгийг нийслэлийн Засаг даргын захирамжийг 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн баталж, Ажлын хэсгийн бүрэлдэхүүний хурлыг 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулж, бэлтгэл ажлын төлөвлөгөө болон төсвийн талаар хэлэлцсэн. | 2024.06.01 2024.08.04 | 30 |
| 4. | **Дэд арга хэмжээ-1.4:** Эко аялал жуулчлалыг хөгжүүлэх Улаанбаатар 360" төслийг боловсруулна. | Хэрэгжилтийн хувь | /--/ | 15% | Монгол улсын Засгийн газраас 2023-2025 оныг "Монголд зочлох жил" болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотод зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, гадаад дотоодын жуулчдыг татах тусгай сонирхлын аяллын бүтээгдэхүүнийг шинээр бий болгох, эко аялал жуулчлалыг дэмжиж "Улаанбаатар хот 360 хөтөч" номыг гаргаж иргэд жуулчдад хүргэхээр төслийн ажлыг судлан Хүрээлэн төслийн баг бүрэлдэхүүнтэй хамтран ажиллахаар 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр нийслэлийн Засаг даргын захирамжийн төслийг бэлтгэж холбогдох удирдах албан тушаалтнуудад танилцуулсан. | 2024.03.01 2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Уг номыг гаргаснаар дараах аяллын бүтээгдэхүүнүүдийг бий болгох зорилтыг тавин ажиллаж байна.<br>1.Гэрэл зургийн аялал<br>2.Ховор ан амьтан ажиглах аялал<br>3.Явган аяллыг хөгжүүлэх<br>4.Дугуйн аялал<br>5.Бартаат замын аялал гэх мэт ховор ан амьтан, байгалийн онцлог бүхий 5 чиглэлд 11 төрлийн аяллын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх боломжтой аяллын товхимол болно. | | |
| 5. | **Арга хэмжээ-1.5:**<br>Аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах зорилгоор өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх | Хөнгөлөлтөд хамрагдсан байгууллагын тоо | 13 | /--/ | Монгол Улсын засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан 2023 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 01-ны өдрийг хүртэл өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх саналыг боловсруулан Tourism.ub.gov.mn сайт Улирлын хямдрал цэсийг үүсгээд байна. Нийслэлийн Аялал жуулчлалын газар page хуудсаар постер болгон олон нийтэд сурталчлан ажиллаж байна. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй үйлчилгээ болон үйл ажиллагаандаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудад 1+1 урамшуулал, 10-50 хувь хүртэл хөнгөлөлт үзүүлэх боломжтой 9 салбарын 62 ААН-ийн 500 гаруй бүтээгдэхүүнийг нэгтгэн хямдралтай аян өрнүүлж байна | 2023.10.01<br>2024.03.01 | 100 |
| 6. | **Арга хэмжээ-1.6:**<br>“City of Nomads through My Lens” Олон улсын гэрэл зурагчдын фестиваль танилцуулга | Хэрэгжилтийн хувь | /--/ | 15% | Олон улсын фото зургийн фестиваль арга хэмжээг зохион байгуулах танилцуулга төслийг бэлтгэж нийслэлийн Засаг даргад танилцуулаад байна. Уг арга хэмжээг зохион байгуулснаар дараах үр дүнд хүрнэ. 80–100 гэрэл зурагчин оролцох ба зурагчин бүр нийгмийн сүлжээнд гэрэл зураг, мэдээлэл цацсанаар ойролцоогоор 1 сая хүнд тус арга хэмжээний мэдээлэл хүрэх. Үүний үр дүнд Улаанбаатар хот төдийгүй Монгол | 2024.04.01<br>2024.04.10 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | орныг зорин ирэх жуулчдын урсгал нэмэгдэх. Тус арга хэмжээний оролцогчид дараачийн аяллаа төлөвлөх, захиалах боломж бүрдэнэ. Улаанбаатар хот өөр нэрийн Олон улсын гэрэл зургийн уралдаантай болох. Гадаад орнуудаас жуулчин авдаг бусад Тур оператор компаниудад Улаанбаатар хот орчмын аяллын шинэлэг санаа, сэдлийг өгөх. Ингэснээр Улаанбаатар хотод аялах хоногийн тоог нэмэгдүүлэх боломж бүрдэнэ Аяллын бус улирлын төрөл зүйл нэмэгдэнэ. гэх мэт олон давуу талууд бий болно. Гэрэл зургийн аялал жуулчлалын нь тусгай сонирхлын аялал бөгөөд өртөг их өндөртэй аялалд ордог тул нийслэлийн эдийн засагт шууд бус орох олгох нэмэгдэх давуу талтай. | | |
| **Зорилт 2:Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4.2** | | | | | | | |
| 7. | **Арга хэмжээ 2.1.** Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, жуулчдад зориулсан арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах | Хэрэгжилтийн хувь | 100% | 70% | “Бүргэдийн баяр”, “Тэнгэр”, “Даншиг наадам-Хүрээ цам”, арга хэмжээний хэвлэлийн мэдээллийг бэлтгэж Хэвлэл мэдээлэл, олон хариуцсан мэргэжилтэн Н.Цолмонгэрэлт цаг тухай бүрт нь бэлтгэж өгсөн. Бүргэдийн баяр-2024 арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Аялал жуулчлалын газраас сурталчилгааны постер, шторкийг рийл бэлтгэн мэдээллийн сувгуудаар түгээж ажилласан.14 сайт, 5 телевиз, 1 радиогоор түгээн сурталчилж ажилласан.Тэнгэр олон улсын фестивалийн хүрээнд сурталчилгааны постер, шторкийг рийл бэлтгэн мэдээллийн сувгуудаар түгээж ажилласан.25 сайт, 2 телевиз, 1 радиогоор түгээн сурталчилж ажилласан. “Данщиг наадам-Хүрээ цам” наадмыг олон улсын 2 сайтад мэдээллийг байршуулан 2024 оны эвент хуанлид байршуулсан. | 2024.02.01<br>2024.08.04 | 100 |
| **Зорилт 3:Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4.3** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8.. | **Арга хэмжээ-3.1:** Улаанбаатар хотын аялал жуулчлалын мэдээллийн санг хөтлөх | /--/ | Мэдээллийн сангийн бүрдэл | /--/ | Гэрэл зургийн эвент зохион байгуулах ажлын хүрээнд фото зургийн аяллаар тэргүүлдэг улс орнуудын судалгаа хийж, тэргүүлэгч 10 орны судалгааг гаргаад байна. Хот болон хот орчмын морин аяллын төрлийг хөгжүүлэх, маршрутын нөөцийн судалгаа хийж 24 маршрутыг танилцуулах судалгааг хийж газрын даргад танилцуулаад байна. | 2024.03.01 2024.05.04 | 70 |
| **Зорилт 4: "Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ"-г боловсруулж, хэрэгжүүлнэ. НЗДҮАХ-3.4.4** | | | | | | | |
| **Зорилт 5: Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 9. | Бодлогын баримт бичгийн тайлан өөрт хамааралтайг гаргаж тайлагнах | Хэрэгжилтийн хувь | 100 | 50% | Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон Нийслэлийн хөгжлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан заалт болон Газрын даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, сайдтай байгуулсан гэрээний биелэлтүүдийн өөрийн албан тушаалын чиг үүрэгт хамаарах заалтын биелэлтийг 1, 2 дугаар улирал болон хагас жилээр гаргаж тайлагнасан. Мөн хагас жилийн хугацаанд зохион байгуулсан 2 эвентийн тайланг хуулийн хугацаанд нь гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | 2024.01.01 2024.06.12 | 100 |
| **Зорилт 6: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 10. | **Арга хэмжээ-6.1** Албан хэрэг хөтлөлтийг заавар, дүрэм, журам, стандартын дагуу зохион бүрдүүлэн хөтлөх, ирсэн бичигйг цаг хугацаанд нь шийдвэрлэх | Шийдвэрлэлт-ийн хувиар | 100% | 50% | Албан хэрэг хөтлөлтийг заавар, дүрэм, журам, стандартын дагуу зохион бүрдүүлэн хөтлөх, 7-ирсэн бичиг, 25 албан бичиг боловсруулж, харилцагч байгууллагуудад уламжилж, шийдвэрлүүлсэн байна. 5 захирамжийн төсөл боловсруулж 3 захирамж батлуулсан. Газрын даргын 2 тушаал бэлтгэсэн. Албан бичиг хугацаа хэтрэлгүй болон зөрчилгүй ажилласан. | 2024.01.01 2024.06.12 | 100 |
| 11. | **Арга хэмжээ-6.2** Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл | Шийдвэрлэлт-ийн хугацаагаар | 100% | 50% | Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт, санал гомдол 2024 оны хагас жилийн байдлаар байхгүй болно. | 2024.01.01 2024.06.12 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүсэлт, санал гомдлыг түргэн шуурхай, нэг мөр эцэслэн шийдвэрлэх | | | | | | |
| 12. | **Арга хэмжээ-6.3** "Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2024 оны архивын материалыг хүлээлгэн өгнө. | Хүлээлгэн өгсөн тоо | 3 | -- | "Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2024 оны 1 дүгээр улиралд 2023 оны 3 баримт материалыг стандартын дагуу архивлан Архив бичиг хэргийн эрхлэгчид хүлээлгэн өгсөн. 2024 оны архивын баримт бичгийн 2025 оны 01 дүгээр улиралд хүлээлгэн өгнө. | 2024.01.28 | 100 |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1. Солонгос хэлний танхимын сургалтад хамрагдаж анхан шатны ярианы хэл сурсан байна. | 138 Кредит цаг | -- | 69 цаг | КОЙКА олон улсын байгууллагын хамтын ажиллагааны хүрээн Солонгос хэлний анхан шатны хичээлд долоо хоног бүрийн 1,3,5 дахь өдрүүдэд хамрагдаж байна. 44 удаагийн хичээлд сууж, анхан шатны үсэг тоо, болон харилцан яриа сурсан. | 2024.02.01 2024.12.30 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2. Төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад хамрагдсан байна. | 24 цаг | -- | 24 | Төрийн худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх А3 сургалтад 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 02 дугаар сарын 1,2-ны өдрүүдэд хамрагдаж, шалгалтад 38 оноо авч гэрчилгээ авсан. | 2024.01.30 2024.02.03 | 100 |
| 3. | Арга хэмжээ3. Монгол бичгийн тооны чадвараа дээшлүүлсэн байна. | Мэдлэгийн түвшин | Сайн | 50% | Төрийн байгууллага 2025 оноос Монгол бичгийг албан хэрэг хөтлөлтөд хослуулан хэрэглэх болсонтой холбогдуулан Монгол бичгийн тооны чадвараа дээшлүүлэхээр цахим хичээл 20 цагийн хичээлийг үзсэн. Үндэсний статистикийн | 2024.01.01 2024.12.30 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газрын түвшин тогтоох шалгалтын сорил өгч сайн үнэлгээ авсан. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. Хот болон хот орчмын морин аяллын маршрутын судалгаа танилцуулга бэлтгэх | Хэрэгжилтийн хувь | /--/ | 100% | Хот болон хот орчмын морин аяллын маршрутын судалгаа танилцуулга бэлтгэж Нийслэлийн Засаг даргын Нэгдүгээр орлогчид танилцуулсан. | 2024.05.01 2024.05.31 | 100% |
| 2. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. Найрсаг Улаанбаатар-2 хөтөлбөрийн биелэлт гаргах, архивлах | Хэрэгжилтийн хувь | /--/ | 100% | Найрсаг Улаанбаатар-2 хөтөлбөрийн биелэлт жилийн эцсийн хяналт шижилгээ үнэлгээтэй холбогдуулан биелэлтийн гаргаж, архивт хүлээлгэн өгсөн. | 2024.01.01 2024.02.15 | 100% |
| 3. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Шинэ сэргэлтийн бодлого хөтөлбөрийн биелэлт гаргах, архивлах | Хэрэгжилтийн хувь | /--/ | 100% | Шинэ сэргэлтийн бодлого хөтөлбөрийн биелэлт жилийн эцсийн хяналт шижилгээ үнэлгээтэй холбогдуулан биелэлтийн гаргаж, архивт хүлээлгэн өгсөн. | 2024.01.01 2024.02.15 | 100% |
| 4. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 5. Жуулчин төгөл танилцуулга бэлтгэх | Хэрэгжилтийн хувь | /--/ | 100% | Цайны замын хүрээнд "Жуулчин төгөл"-ийн танилцуулга мэдээллийг бэлтгэж, Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэнд өгсөн. | 2024.05.01 2024.05.31 | 100% |
| 5. | Үүрэг даалгавар (арга хэмжээ) 7. ХАСХОМ-ийн нэгдсэн дүн мэдээ тайланг гаргаж хүргүүлэх | Хэрэгжилтийн хувь | /--/ | 100% | Байгууллагын эрх бүхий албан тушаалтан буюу ЭБАТ-ын хувь нийт албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг 2024 оны 02 дугаар сарын15-ны дотор нийт албан хаагчдаар бөглүүлж тайлан мэдээг хуулийн хугацаанд гаргаж Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. 2023 онд 14 албан хаагч хөрөнгө орлогын мэдүүлэг гаргасан бол шинэ журмын хүрээнд 2024 онд 5 албан хаагч албан тушаал чиг үүргийн хүрээнд мэдүүлэг гаргана. | 2024.01.01 2024.02.15 | 100% |
| 6. | Сэлбэ голын эрэг дагуух цэвэрлэгээ | Хэрэгжилтийн хувь | /--/ | 100% | Урин дулаан цаг ирсэнтэй холбогдуулан нийт албан хаагчдын хамт Сүхбаатар дүүргийн 14-р | 2024.05.01 2024.05.31 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хорооны нутаг дэвсгэрт байрлах Сэлбэ голын эрэг дугуу цэвэрлэгээ хийсэн. | | |
| 7. | Гадаад харилцааны яамны дэргэдэх талбайн цэвэрлэгээ | Хэрэгжилтийн хувь | /--/ | 100% | Жил бүр нийслэлийн хэмжээнд зохион байгуулдаг хаврын их цэвэрлэгээний хүрээнд дөрөвдүгээр сарын 11-13-ны өдрүүдэд "Нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан хаагчид Гадаад харилцааны яамны урд уулзвараас Төв номын сангийн хойд уулзвар хүртэл хог хаягдлыг цэвэрлэн, дугуйн зогсоол, тамхины цэг, сандал зэргийг угааж, цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлсэн. | 2024.04.01<br>2024.04.30 | 100% |
| 8. | Сансрын И-мартын явган хүний зам цэвэрлэх | Хэрэгжилтийн хувь | /--/ | 100% | Нийт албан хаагчдын хамтаар Сансрын И-мартын явган хүний замын цасыг цэвэрлэж иргэдийн тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн. | 2024.01.01<br>2024.01.30 | 100% |
| 9. | Жуулчин төгөл байгуулах ажлын хүрээнд | Хэрэгжилтийн хувь | /--/ | 100% | "Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэн"-д байрлах "ЖУУЛЧИН ТӨГӨЛ"-д хамгаалалтын зурвасын хайлаас модыг албан хаагчдын хамт тарьсан. | 2024. | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН:

АЯЛЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХӨГЖҮҮЛЭЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН /Б.ЭНХЦЭЦЭГ/ 2024.04.04

( Албан тушаал ) ( Нэр, гарын үсэг ) ( Огноо )

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*4 дүгээр хавсралт*

# ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХАНГУУЛАХ ЯВЦЫН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ (ЗАГВАР)

Албан хаагчийн овог, нэр: Б.Энхцэцэг

Ярилцлага хийсэн огноо: 2024 оны 03 сарын 29 өдөр

Ярилцлагын хэлбэр: (1)Биечлэн 2.Утсаар 3.Цахим хэлбэрээр

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хангалтгүй буюу эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тухай | Нэгжийн даргаас өгсөн үүрэг даалгавар |
|---|---|---|---|
| **Зорилго: Жуулчдыг татах аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, зорин очих газрын дэд бүтцийг сайжруулна. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4.1** | | | |
| 1. | **Арга хэмжээ-1.1:** **Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр олон улсын шинж чанартай арга хэмжээнүүдийг зохион байгуулах** | + | |
| 2. | **Дэд арга хэмжээ- 1.1.1:** **"Бүргэдийн баяр 2024" арга хэмжээ зохион байгуулна.** | + | |
| 3. | **Дэд арга хэмжээ- 1.1.2:** "Бүргэдийн баяр 2024" арга хэмжээний танилцуулга бэлтгэж, төлөвлөгөө боловсруулан газрын дарга, нэгжийн даргад танилцуулан санал авна. | + | |
| 4. | **Дэд арга хэмжээ- 1.1.3:** "Бүргэдийн баяр 2024" арга хэмжээний төсвийн тооцооллыг хамтран зохион байгуулагчидтай нэгтгэн гаргана. | + | |
| 5. | **Дэд арга хэмжээ- 1.1.4:** "Бүргэдийн баяр 2024" арга хэмжээний Нийслэлийн Засаг даргын захирамжийн төслийг | + | |

| | | | |
|---|---|---|---|
| | боловсруулан нийслэлийн удирдлагуудаас санал авч батлуулна. | | |
| 6. | **Дэд арга хэмжээ- 1.1.5**:<br>“Бүргэдийн баяр 2024” арга хэмжээг зохион байгуулах батлагдсан захирамжийн хүрээнд холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулж, зарцуулах төсвийн зардлыг шилжүүлнэ. | + | |
| 7. | **Дэд арга хэмжээ- 1.1.6**:<br>“Бүргэдийн баяр 2024” арга хэмжээний тайланг нэгтгэн Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон санхүүд хүлээлгэн өгнө. | + | |
| 8. | **Арга хэмжээ- 1.1.2:**<br>**“Тэнгэр” бөөгийн олон улсын фестиваль зохион байгуулна.** | + | |
| 9. | **Дэд арга хэмжээ- 1.1.2.1:**<br>“Тэнгэр” бөөгийн олон улсын фестивалийн танилцуулга бэлтгэж, төлөвлөгөө боловсруулан гаргана. | + | |
| 10. | **Дэд арга хэмжээ- 1.1.2.2:**<br>“Тэнгэр” бөөгийн олон улсын фестивалийн төсвийн тооцоолол гаргана. | + | |
| 11. | **Дэд арга хэмжээ- 1.1.2.3**:<br>“Тэнгэр” бөөгийн олон улсын фестивалийн захирамжийг Нийслэлийн Засаг даргын захирамжийн төслийг боловсруулан нийслэлийн удирдлагуудаас санал авч батлуулна. | + | |
| 12. | **Дэд арга хэмжээ- 1.1.2.4**:<br>“Тэнгэр” бөөгийн олон улсын фестивалийн захирамжийн дагуу гэрээ байгуулж, гүйлгээг хийлгүүлнэ. | + | |
| 13. | **Дэд арга хэмжээ- 1.2.5**:<br>“Тэнгэр” бөөгийн олон улсын фестивалийн тайланг нэгтгэнэ. | + | |
| 14. | **Арга хэмжээ- 1.3:**<br>**“Даншиг наадам-Хүрээ цам” шашин, соёлын наадам зохион байгуулна.** | + | |
| 15. | **Дэд арга хэмжээ- 1.3.1:**<br>“Даншиг наадам-Хүрээ цам” шашин, соёлын наадам зохион байгуулах ажлын хэсгийн захирамж гаргана. | + | |

| | | | |
|---|---|---|---|
| 16. | **Дэд арга хэмжээ- 1.3.2:** "Даншиг наадам-Хүрээ цам" шашин, соёлын наадам зохион байгуулах ажлын хэсгийн хурал зохион байгуулна. | + | |
| 17. | **Дэд арга хэмжээ- 1.3.3:** "Даншиг наадам-Хүрээ цам" шашин, соёлын наадам зохион байгуулах төлөвлөгөөг гаргана. | + | |
| 18. | **Дэд арга хэмжээ- 1.3.4:** "Даншиг наадам-Хүрээ цам" шашин, соёлын наадам зохион байгуулах газруудаас төсвийн санал авч нэгтгэж, хөрөнгө гаргах захирамж гаргана. | + | |
| 19. | **Дэд арга хэмжээ- 1.3.5:** "Даншиг наадам-Хүрээ цам" шашин, соёлын наадам захирамжийн дагуу гэрээ байгуулж, гүйлгээг хийлгүүлнэ. | + | |
| 20. | **Дэд арга хэмжээ- 1.3.6:** "Даншиг наадам-Хүрээ цам" шашин, соёлын наадмын тайланг нэгтгэнэ. | + | |
| Жуулчдын зорин очих аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх НХЖТ 2024 – 2.4.157 | | | |
| 21. | **Арга хэмжээ-1.2:** Жуулчдад зориулсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх | + | |
| 22. | **Дэд арга хэмжээ-1.2.1:** Эко аялал жуулчлалыг хөгжүүлэх "Улаанбаатар 360" төслийг боловсруулна. | + | |
| 23. | **Дэд арга хэмжээ-1.2.2:** "Улаанбаатар 360" төслийн захирамж гаргуулна. | + | |
| 24. | "Улаанбаатар 360" төслийн хэвлэмэл мэдээллийн танилцуулга гаргаж олон нийтэд сурталчлана. | + | |
| 25. | **Арга хэмжээ-1.3:** Аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах зорилгоор өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх | + | |
| 26. | **Дэд арга хэмжээ-1.3.1:** | | |

| | | | |
|---|---|---|---|
| | Өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэх боломжтой байгууллагуудын судалгааг нэгтгэн гаргана. | + | |
| 27. | **Дэд арга хэмжээ-1.3.2:** Хөнгөлөлттэй бүтээгдэхүүн үйлчилгээгээр үйлчлэх байгууллагуудын мэдээллийг сайт болон цахим орчинд сурталчилсан байна. | | Байгууллагуудын сурталчилгааг ярaлтай цахим орчинд байршуулах, нэмэх |
| **Зорилт 2:Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4.2 Зорилт** | | | |
| 28. | **Арга хэмжээ 2.1.** Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, жуулчдад зориулсан арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах | + | |
| 29. | **Дэд арга хэмжээ 2.1.1.** "Бүргэдийн баяр", "Тэнгэр", "Даншиг наадам-Хүрээ цам", арга хэмжээний хэвлэлийн мэдээний төслийг бэлтгэж өгнө. | + | |
| **Зорилт 3:Жуулчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр олон талт арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна. НХТЖҮЧ-4.3, НЗДҮАХ-3.4.3** | | | |
| 30. | **Арга хэмжээ-3.1:** Улаанбаатар хотын аялал жуулчлалын мэдээллийн санг хөтлөх | + | |
| 31. | **Дэд арга хэмжээ 3.1.1.** Олон улсын аялал жуулчлалд нэвтэрч буй бүтээгдэхүүн үйлчилгээний судалгааг гаргаж, мэдээллийн санг үүсгэнэ, | + | |
| 32. | **Дэд арга хэмжээ 3.1.2.** Дотоодын аялагчдад зориулсан өвлийн аяллын төрлийг судлах, бий болгох | + | |
| **Зорилт 4: Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд:** | | | |
| 33. | **Арга хэмжээ-4.1** Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээ болон бусад холбогдох тайлан мэдээг сар, улирал, жилээр цаг тухай бүрд гаргаж хүргүүлнэ. | + | |
| **Зорилт 5: Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:** | | | |
| 34. | **Арга хэмжээ-5.1** | | |

| | | | |
|---|---|---|---|
| | Албан хэрэг хөтлөлтийг заавар, дүрэм, журам, стандартын дагуу зохион бүрдүүлэн хөтлөх, ирсэн бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэх | + | |
| 35. | **Арга хэмжээ-5.2** Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт, санал гомдлыг түргэн шуурхай, нэг мөр эцэслэн шийдвэрлэх | + | |
| 36. | **Арга хэмжээ-5.3** “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2024 оны архивын материалыг хүлээлгэн өгнө. | + | |

**ЯРИЛЦЛАГА ХИЙСЭН:**
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА С.ТУУЛ ............................................ /С.ТУУЛ/

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )*